



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар A/64

Улаанбаатар хот

Орон нутгийн нисэх буудлуудын
үйл ажиллагааг хэвийн горимд
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.6 заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн шуурхай зөвлөгөөний шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн нисэх буудлуудын зарим ажлын байранд сул зогсолт хэсэгчлэн зарласан хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан нисэх буудлын үйл ажиллагааг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Нисэх буудлуудын үйлчилгээний газар (С.Нацагдорж)-т үүрэг болгосугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН